

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

*1.Улсын Их Хурдын тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн
хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт
бэлтгэх тухай/* 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны
05 дугаар сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 31 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Н.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ.

Нэг.Улсын Их Хурдын тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 1
Бүгд: 15
93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 15 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр,
Баасан гараг

Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим 17 цаг 31 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ оройн мэнд хүргэе. Гишүүдийн ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 5 сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Нэг.Энэ удаагийн хуралдаанаар бид Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай хүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Гишүүдэд тогтоолын төсөл танилцуулсан байгаа. Гэхдээ сая чуулган дээрээс бас Их Хурлын дарга чиглэл өглөө. Пүрэвдорж гишүүн санал гаргасан. Тэрний дагуу 1 заалт нэмээд тогтоолын төсөл бэлдсэн байгаа. Би одоогоор уншаад танилцуулчихъя. Тэгээд та бүхэн саналаа хэлнэ биз.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуульд 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Н.Энхболд Улсын Их Хурлын гишүүн, Гишүүд: Ш.Адъяа Улсын Их Хурлын гишүүн, Ж.Батсуурь Улсын Их Хурлын гишүүн, Т.Батдорж, Адъяаа, Адъяаа. Уучлаарай Адъяаа гишүүн, Т.Доржханд Улсын Их Хурлын гишүүн, Х.Нямбаатар Улсын Их Хурлын гишүүн, Д.Сарангэрэл Улсын Их Хурлын гишүүн, Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын гишүүн, О.Цогтгэрэл Улсын Их Хурлын гишүүн, Б.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангах, холбогдох хуульд заасан хугацаанд багтаан хангаж ажиллахыг ажлын хэсэг Энхболдод даалгасугай.

3.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэгт болон ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлж ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газар Өлзийсайханд даалгасугай.

4.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, санал бодлыг сонсох ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, холбогдох зардлыг гаргахыг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэд үүрэг болгосугай.

5.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг тус тусын нутаг дэвсгэрт гэх үү, хариуцан зохион байгуулж ажиллахыг холбогдох Засаг дарга нарт үүрэг болгосугай гэсэн ийм агуулгатай 5

дахь заалт нэмээд ийм тогтоолын төслийг санал болгож байна.

Энэ дээр айн 6? тухайн гэдгийг, тухайн нутаг дэвсгэртээ зохион байгуулахыг холбогдох Засаг дарга нарт үүрэг болгосугай. Аймаг, Нийслэлийн Засаг даргад гэсэн ч болно.

Хамгийн сүүлд, айн? Тэгье, тэгж бич. Бичиж аваарай харьяалах засаг захиргааны нутаг дэвсгэрийн хэмжээнд гэх үү тийм ээ, зохион байгуулах. Тэгье хуулийнхаа дагуу бичээд Сүхбаатар гишүүнд нэг үзүүлээдхээрэй. Эцсийн хувилбараа.

Ингээд 6-д нь энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Өөр саналтай гишүүн байна уу? Нэгжид бүх шатын Засаг дарга нар тухайн нэгжгийн хурлууд гэсэн утгаар бас. Тэрийг нь бас оруулъя. Сүхбаатар гишүүнд нэг үзүүлчхээрэй. Зарчмын хувьд ингээд баталчихъя. Тэгээд үг, үсгээ үзүүлчхээд чуулганд оруулчихъя тэгэх үү?

Саяын тогтоолын төсөлтэй танилцаад, гишүүдээс гаргасан саналыг оролцуулаад, хэлэлцүүлэхийг батлахыг дэмжье гэж томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Чуулганы нэгдсэн хуралдаанд оруулна.

Ерөнхийд нь энийг үндэслээд Их Хурлын дарга бас захирамжаа гаргах ёстой.

15 гишүүнээс 14 нь дэмжиж, 93.3. Адыасүрэн гишүүн бас дэмжсэн юм байна. Бас юм нь биш аппарат нь ажиллаагүй байна. Тийм ажиллаагүй байна. Ингээд 100 хувийн саналаар дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Оюунчимэг гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа. Гишүүддээ баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

17.36 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР